

Д.Баярхүү

Оросын либерал  
империализм

Д.Баярхүү

Хятад төрийн залгамжлал  
– 6 дахь үе

ШХАБ-Д ЖИНХЛЭХ ҮҮ,  
АЗНАХ ҮҮ ?

# БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2018.03 №7




Бодлогын судалгааны төв  
Монгол Улсын Их Сургууль  
Олон Улсын Харилцаа,  
Нийтийн Удирдлагын Сургууль

РЕДАКЦИЙН ЗУРВАС  
01

ХӨРШ ОРНУУД  
02 Оросын либерал империалэм

ХӨРШ ОРНУУД  
04 Хятад төрийн залгамжлал – 6 дахь үе

ОНЦЛОХ СЭДЭВ  
06 ШХАБ-д жинхлэх үү, азнах уу?



Дугаарыг эрхлэн бэлтгэсэн:

Х.Бэхбат

Эх бэлтгэгч:  
Хэвлэсэн газар:

Х.Балдандорж  
"Удам Соёл" ХХК

Нохой жилийн хавар

Энэ гуравдугаар сард манай урд, хойд хоёр хөршид улс төрийн нэн чухал үйл явдлууд болж өнгөрлөө. Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их хурлын ээлжит чуулган хуралдаж, В.Путин ОХУ-ын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдов. Эдгээр үйл явдлын үр дагавар нь энэ хоёр улсын төдийгүй дэлхий нийтийн хувьд ямар байх талаар зөгнөн тааварлах, урьдчилан дүгнэх ажил аль хэдийнээ, хааяагүй хүчээ авчээ.

Үүнтэй холбогдуулан манай улсын хувьд гэвэл ганцхан зүйлийг онцолмоор санагдав. Хоёр хөршийнхөө бодлогын судалгааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд анхаарцгаамаар байна. Орос судлал, хятад судлалын чадавхиа бэхжүүлмээр байна гэж...

“Бодлогын мэдээ”-нийхээ өмнөх дугаарт амалсан ёсоор ШХАБ-ын талаар зарим судлаачдын баримталж буй байр суурь, санаа бодлоос энэ удаа ч эшлэн нийтлэв. Та ч бас дээрх хоёр үйл явдал, түүний бодлогын агуулгыг ШХАБ-ын нөмрөг дор дахин эргэцүүлээд үзээрэй. Хөрш хоёр маань энэ байгууллагын хувьд юу билээ, манлайлан хөтлөгч бус уу?

Х.Бэхбат

\* \* \*

Politics is war without bloodshed, while war is politics with bloodshed.

Mao Zedong

In politics, nothing happens by accident. If it happens, you can bet it was planned that way.

Franklin D. Roosevelt

In our age there is no such thing as 'keeping out of politics. All issues are political issues, and politics itself is a mass of lies, evasions, folly, hatred and schizophrenia.

George Orwell



Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

# ОРОСЫН ЛИБЕРАЛ ИМПЕРИАЛЗМ

Оросын либерал империализм хэмээх нэр томъёо Оросоос өөрөөс нь зарим үед цухалздаг. Үүнийг шинэ үеийн оросууд нь “XXI зууны Оросын түүхэн үүрэг” хэмээн нэрлэдэг. Ухаан нь либерал эзэнт гүрэн байгуулах нь Оросын төрт-улсын гол зорилт байх болно гэж нотлох нь холгүй байна. Крымыг өөртөө хавсарган нэгтгэж байгаагаар нь бол либерал империализм бараг төрчихсөн мэт.

В.Путинээр төлөөлүүлсэн Кремлийнхэн (хүчнийхэн) ба мафижсан олигархи хоёрын өөр хоорондын ширүүн тэмцэлд эхнийх нь ялж байх шиг. Шинэ Оросын нийгмийн дүр төрх нь эрх мэдэл, мөнгө санхүү, бизнесийн хувь заяаг хэн нь шийдэх вэ, чекистүүд ба бизнесийн хоорондын тэмцэл ямар шатандаа вэ гэдгээр заримдаа тодорхойлогдоод байх шиг байна.

Зарим судлаачдын бичсэнээр Орост үндсэн 4 хүчний завсарт эх орных нь хувь заяа эргэлдэж байгаа бололтой. Энэ бол XX зуунаас улбаатай өнгөрсөн коммунизмынх нь сэтгэхүйн үлдэгдэл, нөгөө талаасаа бол нийгэм-улс төрийн хөдөлгөөн ч юм уу, нийгмийн сэтгэл зүй ч юм уу гэмээр, дүрсэлбээс Орос орныг 4 тийш нь чангааж буй бодитой хүч юм. Эдгээр нь:

1) СССР руу ухрагсад Оросын нийгэмд маш хүчтэй байна. Гэвч түүхийн хүрдийг буцааж

болдоггүй тул явуургүй, гэхдээ үүнийг хүсэгчид мөддөө Орост байсаар байх төлөвтэй.

2) Национал-патриотууд. “Орос орон зөвхөн оросуудынх” гэсэн эдний уриа нь олон үндэстний, олон иргэншил соёлтой, олон шашинтай, хэтэрхий нүсэр Орос орныг сүйрүүлэх тул бас явуургүй, гэхдээ нийгмээсээ ямар нэгэн дэмжлэгтэй тул мөн оршин байсаар л байна.

3) Оросыг Евразичлах талынхан. Эд мөн эх оронч царай гарган популизм хийх тул ихээхэн дэмжлэгтэй, мөддөө оршин үлдэнэ.

4) СССР нь Орос гүрний аль олигтой сайн сайхныг үгүй хийсэн тул Цагаан хаант Оросын үеийн ариун нандин шүтээн рүү эргэж очих хэрэгтэй гэж үздэг 4 дэх хэсэг бий. Дэмжлэг илүү хүлээх магадлалтай, эрх баригчид нь бараг энэ талынхан гэмээр.

Дээрхи 4 үзэл баримтлалыг тойрсон улс төрийн тэмцэл перестройкийн үеэс эхлэн үргэлжилсээр СССР-ийн тарахыг үзэж эдүгээ Орос оронд ил, далд оршиж буй. Саяхны мэт боловч улирч одсон нэгэн түүх: 1993 онд Москвад зэвсэгт мөргөлдөөн дэгдэж, Ерөнхийлөгч, Дээд Зөвлөл хоёр нь талцан үзэлцсэн нь ийм төрлийн тэмцлийн дээд оргил үе нь юм.

Нэгэн үе Оросын улс төрийн тэнгэрт од болсон, эдүгээ олигархийн гол төлөөлөгч байж мэдэх А.Чубайсын үзэл бодол үе үе анхаарал татдаг. XX зуунд Орос орны туулсан фантастик замнал нь дээр дурдсан эх захгүй их тэмцлийн гол шалтгаан хэмээн тэрээр арваад жилийн тэртээ ярьж байсан. Дэлхий дээр өөр ямар ч улс үндэстэн туулаагүй тийм фантастик замаар Орос гүрэн тавьхан жилд замнаж, тохиолдсон адал явдлууд нь санаанд багтамгүй их масштабаар явагдсан хэмээн А.Чубайс түүхээ зүхсэн байдаг ба тэр үзэлдээ үнэнч явсаар өнөө хүрсэн. Тэгж ярьсан нь ч гөрдлөг биш, үнэн түүхийг л үнэнээр нь өчсөн хэмээн би боддог.

Яагаад үнэн гэж? Ленин, Сталины үүсгэсэн хувьсгалын их үйл хэрэг иргэний дайн гээч яргалалд хүргэж ахар богино хугацаанд Оросын 13 сая хүний амь аван оджээ. Дараа нь залгуулаад НКВД-гийн шорон, бөөнөөр хорих лагерь, колони цөллөгт 20 сая хүн ардыг цааш харуулж, Оросын сэхээтний давхарга бараг устжээ. Үүнтэй зэрэгцэн аж үйлдвэржүүлэлт, хамтралжуулалт явагдаж, дэлхийн хамгийн ядуу, анжистай хоцрогдсон орныг цөмийн зэвсэгтэй тэргүүний гүрэн болгож чаджээ. Дэлхийн II дайнд Орос орон 30 сая иргэнийхээ алтан амийг өргөжээ. Орос нь өөрийгөө тойруулсан 14 улсыг нэгтгэж, 250 сая хүн ардыг захирч байснаа II дайны дараа дахин 11 тусдаа улсыг дагуулаа болгож социалист лагерь байгуулан 1.5 тэрбум хүн ардыг (Монголын тусгаар тогтнолыг дэлхийд хүлээн зөвшөөрсөн, Монголын хөгжил цэцэглэл энэ хүрээнд хамаарна) улаан тугийн дор нэгтгэжээ. Энэ бүхэн XX зууны түүхийн 30-40 жилийн дотор шуурч өнгөрчээ.

Түүхэндээ Македоны Александр хаан, доголон Төмөр, Наполеон, Гитлерийн хэн нь ч ийм том үйл хэргийг ийм богино хугацаанд хийгээгүй. Гэтэл энэ их алдар гавьяа нь ялагдлын хөрсийг буй болгосоор, тэр нь тэлсээр тэлсээр вертикаль иерархи системийг нураасан. Берлиний хана нурж, дараа нь ЭЗХТЗ тарж, дараа нь Варшавын Гэрээ устаж, эцэст нь СССР өөрөө задарсан гэхчлэн.

Энэ бүх ялагдлыг эргээд нөхвөрлөх нь сэтгэшгүй, бүтэшгүй зүйл мэт боловч ямартай ч Гүржийг хагалан гурав хувааж, өөртөө хоёр дагуул улс буй болгож, Украины Крымыг нь Орост нэгтгэж, Донбасст ДНР, ЛНР гэх хоёр “БНУ” тунхаглуулж, хэрэв мөд Днестр мөрний зүүн эргийн Молдавыг ийм замаар оруулбал бас ч үгүй шинэ эзэнт гүрний гэрэл гэгээ байх шиг. Үүний тулд нөгөөх либерал империализмын үзлийг Орос гүрний гол үзэл суртал болгоё гэсэн санал шийдэлд хүрч таарна. XXI зуунд ялан мандах, дэвжин дээшлэх гол туг нь Оросын хувьд либерал империализм хэмээн Чубайс ба бүр барууны хүчнийхэн - СПС нам хүртэл шууд уриалан дууддаг. Крым дээр Төрийн Дум байтугай гудамжинд байгаа данс бүртгэлтэй Оросын улс төрийн бүх нам хөдөлгөөн нэгэн зэрэг уухайлсан нь үүний нотолгоо болов уу.

Энэ дэвсгэр дээр авч үзвэл Орост “иргэншил”, “ардчилал”, “хувийн өмч”, “зах зээл”, “эрх чөлөө”, “орос иргэний эрх ашиг” гэсэн ойлголтууд бүгд нэг дор зэрэгцэн хөгжих ёстой болж байна. Үүнд хүрэхийн тулд Оросын бизнесийн экспансыг тэлэхэд төр нь туслах ёстой ба Оросын соёл нь ч мөн экспанс хийх цаг нь болсон хэмээн нийтээрээ үздэг.

Оросын стратегийн боломжуудыг оновчтой ашиглах нь бизнесийн экспанс (соёл дагалдана) хийх утгвар нөхцөл болно. Оросын стратегийн боломж гэдэгт: дэлхийн байгалийн баялгийн 38 хувь нь Орост хуримтлагдсан. Үүнд ойн баялгийн 25 хувь, газрын тосны 15 хувь, байгалийн хийн 42 хувь, нүүрсний 43 хувь гэх мэт жагсаавал дуусашгүй. ОХУ нь Украины түүхий эдийн хэрэгцээний 80 хувь, Балтийн орнуудын 100 хувь, Дорнод ба Төв Европын орнуудын 50 гаруй хувь, Баруун Европын орнуудын хэрэгцээний 20-30 хувийг дангаараа хангадаг байсан, байгаа. Европынхны газрын тосны үлэмж хувийг Оросоос нийлүүлж ирсэн. Дэлхийн зах зээл дээрхи газрын тосны 43 хувь, байгалийн шатдаг хийн 36 хувь, модны 25 хувийг Орос дангаараа нийлүүлдэг байсан саяхны тоо баримт байна.

ОХУ нь газар зүй-геополитикийн хосгүй байршилтай, энэ үзүүлэлтээр түүнтэй өрсөлдөх өөр улс үндэстэн байхгүй, Евразийн цорын ганц гүрэн Орос нь оюуны ба шинжлэх ухааны асар их чадавхитай, цэрэг-аж үйлдвэрийн хүчирхэг бааз суурьтай, олон улсын харилцаанд хүчтэй, нөлөөтэй тоглогч (Сириэр жишээлээд) гэхчлэн хүчин зүйлсийг харгалзах хэрэгтэй.

Харамсалтай нь дэлхийн эдийн засагт Оросын эдийн засаг ямар байр суурьтай вэ гэвэл яг одоо сайнаар дуудуулахаар биш байна. Эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлт, ард түмний амьжиргааны түвшний үзүүлэлт гэвэл сайнгүй. НҮБ-ын хөгжлийн доогуур түвшний үзүүлэлтээр Орос орон дэлхийд хойгуур бичигддэг гээд эхэлнэ. Дэлхийн ДНБ-ий өсөлтөд СССР-ийн эзлэх жин 1980-аад онд 21 хувьд хүрч байсан бол одоо ОХУ-ын эзлэх жин 2 хувийн наана цаана. Бүтээсэн баялгаар нь (ДНБ) улс орнуудын дунд ОУВС-гаас 2017 оны рейтинг гаргаж үзжээ. Эхний байрт АНУ 19.4 триллион долларын баялаг бүтээнсээрээ шалгарчээ. Араас нь Хятад (\$11.9 триллион), гуравт Япон (\$4.9 триллион), дөрөвт Герман (\$3.7 триллион), Франц (\$2.5 триллион), Их Британи (\$2.5 триллион), Энэтхэг (\$2.4 триллион) гэхчлэн жагсаж байна. Өмнөх гурвал жилийн рейтингийн судалгаагаар Орос 12-т жагсаж байсан ба 2017 онд мөн 12-т \$1.4 триллион гэж гарчээ. Энэтхэгийн араас Бразил, Итали, Канад, Өмнөд Солонгос (Оросын өмнө), Оросын ард Австрали, Испани, Мексик гэхчлэн жагсаж байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг топ 10 эдийн засаг гэдэгт АНУ, Хятад, Япон, Герман, Их Британи, Франц, Энэтхэг, Итали, Бразил, Канад хэмээн жагссан байх ба АНУ-ын эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн 24.3 хувь, Хятадынх 14.8 хувь, Японых 5.9 хувь, Германых 4.5 хувь гэхчлэн жагсахад Оросынх бүр сүүлээр 1.8 хувь гэж бичигджээ.

Харин өөр нэг буруу үзүүлэлтээр толгой цохиж яваа судалгаа байна. Сүүдрийн буюу буруу гарын эдийн засагтай 28 улсыг жагсаахад Орос нь

2017 онд эхний 5 дотор орж иржээ. Тус орны ДНБ-ий 39 хувь нь далд эдийн засгаас босдог, Оросын өмнө нэгд Украин (ДНБ-ий 46 хувь), Нигериа (48 хувь), Азербайжан (67 хувь), тэгээд Орос, араас нь Шри-Ланка (38 хувь) гэхчлэн харанхуй тоонууд чухам юу өгүүлнэ вэ?

Гэхдээ харанхуй тоо байлаа гээд түүнийг нь өөр талаас нь нөхвөрлөх үзүүлэлт байна. Булчин шөрмөс сайтай, хэний ч дор орохгүйгээр барахгүй бүр айлгахаар үзүүлэлт. Цэрэг армиараа дэлхийд хошуучлагчдын нэг. Цөмийн зэвсэг, стратегийн зэвсэглэл гэвэл дэлхийд хоёрт орно. Одоо 1 сая 40 мянган цэрэг албандаа, цаана нь 2 сая гаран резервист бэлэн байна. Иймээс дэлхийд манлайлдаггүй юм аа гэхэд ядаж түншлэх, эрх тэгш харилцах хэмжээнд очих тухайд гарц бэлэн байна. Тийм гарцыг улс төрчид, чекистүүд, генералитет, бизнесчид, мафийнхан бүгд л хайцгаасаар, эцсийн бүлэгтээ либерал империализмын үзэл дээр тэд нэгдэхээс өөр замгүй. Тийм гарцыг юуны өмнө СССР-ийн орон зайгаас эрнэ. “Пост-совет” орон зайд Оросын нөлөөг бататгах зорилго бүхий ОДКБ, Евразийн эдийн засгийн холбоо, Гаалийн Холбоо, ЕЭП, ЦАС, СНГ (2) зэрэг цаанаа улс төр, цэргийн агуулгатай байж болох элдэв бүтэц олноор төрж байгаа билээ. “Пост-совет” орон зайд Орос азаргалах өөр шалтгаан байна. Москвад мөргөлдөөн, цус урсгасан зэвсэгт тэмцэл өрнөж, Чеченд ард түмэнтэйгээ дайтаж байсныг нь орхилоо гэхэд хуучин СССР-ийн гишүүн Тажикистаны 10 жилийн иргэний дайн, Гүрж, Азербайжанд явагдсан удаа дараагийн төрийн эргэлтүүд, Молдова дахь зэвсэгт мөргөлдөөн, үндэсний хуваагдал, 2004 оны Гүрж, Украины, 2013-2014 оны Украины өнгөт хувьсгал гэхчлэн жагсаалт тоймгүй урт бий. Ардчиллын эсрэг хууль бус үйлдлүүд, сонгуулийн шамшигдуулалт, дийлдэхээ больсон хээл хахууль гэхчлэн “ид шид”-ийг үзүүлэхээр баримтууд улс бүр дээр нь дэндүү олон байна. Ийм хөрсөн дээр Оросын либерал империализм босч ирэхгүй гэж үү?



Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

# ХЯТАД ТӨРИЙН ЗАЛГАМЖЛАЛ 6 ДАХЬ ҮЕ

ХШ сонгуулийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын (БХАТИХ) анхдугаар чуулган олонхийн саналаар Үндсэн хуульд засвар оруулах төслийг баталсан. Энэ нь Хятадын улс төрийн тогтолцоо цаг үетэйгээ зэрэг урагшилж буйг нотлон харуулсан хэрэг хэмээн хятадууд өөрсдөө үздэг. Бусад улс орны улс төрийн тогтолцоотой харьцуулбал Хятадын улс төрийн тогтолцоо өөрийн гэсэн өвөрмөц давуу талтай хэмээн тэд тайлбарладаг. Яг одоо Хятад улсын эрчтэй хөгжил, ялангуяа эдийн засгийн талаархи асар их ололт амжилт нь маш олон улс оронд зээлдэн суралцууштай арга туршлага болсон байж болно. Хятад улс реформ, нээлттэй бодлого хэрэгжүүлсэн 40 жилдээ асар их амжилтад хүрсэн ба эдүгээ ядуу хүн ам, хот хөдөөгийн хөгжлийн зөрүү, байгаль орчны бохирдол зэрэг олон зүйлийн олон сорилттой тулгарч буй. Гэвч цаашид өөрчлөлтийн эрчээ өсгөж, хөгжлийнхөө явцад элдэв бэрхшээлээ зохицуулж бүрэн чадна, үүний тулд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, удирдлагын асуудлыг шийдвэрлэлээ хэмээн Бээжингийн суртал нэвтрүүлэг

ярьж, тэмдэглэж байна.

Өмнөх намын их хурлууд, БХАТИХ-ын чуулгануудын үеэр төд дэх үеийн удирдагчдаа тийм албан тушаалд дэвшүүлээ хэмээн нэрлэж, сурталчилж, тухайлбал одоогийн Си Жиньпин даргыг 5 дахь үеийн удирдагч гэдэг байсан бол өнгөрсөн ХКН-ын XIX их хурал, саяхны ардын их хурлын чуулган дээр таг чиг өнгөрсөн нь анхаарал татна.

Хөгжил хурдсах тусам нэг хүний засаглалаар хөгжлөө баталгаажуулья гэх санаа нэвт мэдрэгдэнэ. Си дарга залгамжлагч, залгамжлал, 6 дахь үеийн удирдагчийн талаар ил ярихгүй байгаа нь өөрийнх нь дэвшүүлсэн Хятадын онцлог бүхий социализмын шинэ эрин- “Хятад мөрөөдөл”-тэй нь холбоотой гэх тайлбар ч хангалттай явж байна.

Өнөөгийн Хятадын удирдагчид болох Си Жиньпин, Улсын дэд дарга Ван Чишан, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жяньшү, Ерөнхий сайд Ли Көцян, Хятадын Ардын Улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бүх Хятадын хорооны дарга Ван Ян нар бол БНХАУ-ын 5 дахь үеийн удирдагчид гэгдэнэ.

Дөрөв дэх үеийнхэн нь

Ху Жинтао, Вень Зябао, У Банго нар, гурав дахь үеийн удирдагчид нь Зян Зэминь, Ли Пэн, Цяо Ши, Жу Рунжи, дахиад өмнөшөө хоёр дахь үеийн удирдагчид нь Дэн Сяопин, Чэнь Юнь, Е Зяньин, Ли Сяньян нар гэж албан ёсоор нэрлэдэг.

Тэгвэл нэгдүгээр үеийн удирдагчид нь хятадын ардын хувьсгалыг удирдсан Мао Зэдун, Жоу Энълай, Лю Шаоци, Жү Дэ нар хэмээн Хятадын албан ёсны түүхэнд тэмдэглэдэг.

Харин энэ удаа 6 дахь үеийн удирдагчдын талаар яагаад тэгтлээ ярихгүй, зарлахгүй байгаа нь гадаадын хятад судлаачдын анхаарал татна. Элдэв таамаг дэвшүүлж, хүний нэр ус зоож, тэр тэр нар 6 дахь үеийн удирдагч, ирээдүйд Си Жиньпинийг залгамжлагч болно гэх элдэв мэдээлэл гадаадын сайтуудаар явж байна.

Хэд хэдэн хүний нэр яригддагийн дотор Ху Чунхуа гэх нэг эрхмийн нэр дуулддаг. Тэрээр ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, Гуандун мужийн намын хорооны дарга байж байгаад саяхны чуулганаар Ерөнхий сайдын орлогч болжээ. 1963 онд төрсөн, одоо 55 настай, насны хувьд



яалт ч үгүй залгамж халаа гэж хардах үндэстэй. 2022 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын хороонд сонгогдох магадлалтай. Туулсан зам нь яруу бөгөөд баялаг. Хятадын Комсомол, Түвд, Хэбэй муж, Өвөр Монголд ажиллаж байгаад одоо Хятадын хамгийн хүчирхэг мужийг сүүлийн хэдэн жил удирдлаа. Гуандун мужийн ДНБ гэхэд л Оросынхоос хэд дахин давж байна. Энэ мужийг Хятадын эдийн засгийн локомотив гэж нэрлэдэг ба өмнө нь энэ мужаас Ван Ян дэвшиж, төвд очиж Ерөнхий сайдын орлогч болж байжээ. Ван Ян бол “Нэг бүс-Нэг зам” гэх лут төслийн үзэл санааны анхдагч, Си даргын баруун гар гэгддэг. Энэ мужаас Жао Зыян, Си Жүнсюнь (Си Жиньпиний аав), Ли Чаньчунь, Жан Дөзян зэрэг нэрт улс төрчид ажлын гараа, улс төрд өгсөх замаа засч байжээ.

Саяын чуулганы зарим томилгоо дэлхий нийтийн анхаарал татлаа. Засгийн газарт хяналтын ба эдийн засгийн чиглэлийнхэн давамгайллаа. Си даргын зөвлөх, Улс төрийн Товчооны гишүүн 66 настай Лю Хэ Ерөнхий сайдын орлогч болсныг ихээхэн шуугиж хүлээн

авлаа. Хятадын эдийн засгийн дэвшилтэт, идэвхтэй загвар эрэлхийлэгч, олон улсын маш олон асуудал дээр ажиллаж байсан, англи хэлийг сайн эзэмшсэн, америкийн эдийн засгийн сайн мэдлэгтэй, 2018 оны Давосын эдийн засгийн форумд оролцсон гээд түүн дээр дагалдах тайлбар зөндөө. Хятадын Ардын Банкны дарга болсон И Ган дээр акцент их өгч байна. Санхүүгийн салбарт аядуу бодлого явуулагч, санхүүгийн тогтвортой байдлыг хангагч, Хятадын мөнгөний бодлогыг олон жил хөтлөлцсөн, олон улсын томхон банкны холбоодтой хэлхээ холбоо сайтай, тэр утгаар Лю Хэ, И Ган нар Хятадын эдийн засгийг хөтлөн явуулах боллоо, тэр хоёр ДНБ-тай харьцах дотоодын их өрийг (260 хувьд хүрсэн) цэгцлэхээр ажиллана гэж таамаглацгааж байна.

Саяхны чуулганаар 4-5 чухал нөхөд шат ахисны дотор Гадаад хэргийн сайд Ван И зүй ёсоор орно. Тэрээр сайдаа хийхийн сацуу Төрийн Зөвлөлийн гишүүн (нэг үгээр Шадар сайд) болсноор Хятадын бодлогод нөлөө бүхий фигур боллоо. Хятадын ГХЯ-ны үүрэг ч өсөөд

явчихлаа. Энд би Ху Чунхуа, Лю Хэ, И Ган, Ван И нараар 6 дахь үеийн удирдагчдын нэрс гаргах гээгүй гэдгээ өчсү.

Бас нэг онцлог үйл явдлыг нэрлэх хэрэгтэй. Урьд оны намар нь ХКН-ын их хурал хуралдаж, намын дээд байгууллагыг сонгоход Зян Зэминь, Ли Пэн, Жу Рунжи нар төрийн дээд тушаалдаа үлдэж, харин намын удирдлагаас хасагдан хэдэн сарыг өнгөрөөж, дараа жилийн хавар нь БХАТИХ-ын чуулган хүргэж байж улс төрөөс бүрмөсөн явсан, Ху Жинтао, Вэнь Зябао, У Банго нар мөн тэгсэн, энэ удаа Байнгын Хорооны дарга Жан Дөзян мөн тэглээ. Өөрөөр хэлбэл Хятадын Төрийн тэргүүн, парламентын дарга, Ерөнхий сайд нар нь намынхаа дээд сонгуульт албан тушаалгүй хэдэн сарыг үдэж байсан байх юм.

Эдүгээ Хятадын хөгжлийн үзэл санааны хөтөч онол-баримтлал нь нэг нэг удирдагчийн нэртэй салшгүй холбоотой. Маркс, Лениний онол болон Мао Зэдунгийн үзэл санаа, Дэн Сяопиний онол, гурвыг төлөөлөх үзэл (Зян Зэминь), шинжлэх ухаанч хөгжлийн үзэл (Ху Жинтао), Хятадын онцлогтой социализмын шинэ эрин үеийн тухай Си сЖиньпиний үзэл санаа гэх мэт.

Орчин үеийн Хятадын түүх гурван аугаа их удирдагчийг төрүүлсэн: Шинэ Хятадыг байгуулж, тусгаар тогтноулж, хөлд дээр нь босгож бие даалгасан Мао Зэдун, шинэчлэлийн салхи хагалж реформоор Хятадыг хөгжүүлсэн Дэн Сяопин, шинэ эрин үед Хятадыг удирдаж яваа Си Жиньпин хэмээн Хятадад үздэг болжээ.

# ШХАБ-Д ЖИНХЛЭХ ҮҮ, АЗНАХ ҮҮ ?

МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль /ОУХНУС/, түүний дэргэдэх Бодлогын судалгааны төвөөс “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/ - Монгол Улсын цаашдын оролцоо” гэсэн сэдвээр судалгааны хэсэг гарган ажиллуулсан юм. Судалгааны багийг Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ч. Баатар ахалж, ГХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дэд захирал Б. Дорж, ОУХНУС-ийн багш, доктор Н. Алтанцэцэг, Б. Санжмятав, С. Баясгалан нар орж ажилласан болно.

Уг сэдэвтэй холбогдуулан эрдэмтэн судлаачид, олон улсын харилцааны мэргэжилтнүүд оролцсон хэлэлцүүлгийг хоёр удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт оролцсон судлаачдын цөөнх нь Монгол Улс ШХАБ-д гишүүн болох хэрэгтэй гэж үзэж байсан бол олонхи нь одоогоор идэвхитэй ажиглагч байх нь чухал гэсэн байр суурьтай байв.

Өмнөх дугаарт Монгол Улс ШХАБ-д гишүүн болох нь зүйтэй гэсэн судлаачийн байр суурийг нийтэлсэн тул энэ удаад өөр байр суурь бүхий судлаачдын, тухайлбал Стратеги судлалын хүрээлэнгийн судлаач Г.Базарваань, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн судлаач К.Дэмбэрэл, Н. Соёлгэрэл, Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач Т. Сүхбаатар, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн судлаач Х. Болдбат, Дипломатын Академи ТББ-ын захирал Х. Бэхбат нарын санаа бодлыг дээрх нэгэн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс авч нийтэлж байна. Үүнд:

## Ч.БААТАР:

ШХАБ байгуулагдаад 17 жил болж байна. ШХАБ-д манай улс 2004 онд ажиглагчийн статустай болж түүнээс хойш ажиглагчаар явж ирлээ. Цаашид манай улс яах вэ, ажиглагчийн статусаа хэвээр хадгалаад явах уу, эсвэл гишүүн болох юм уу гэсэн асуудал гарч байгаа. Энэ асуудлыг баг гарган судлаж манай төр засгийн удирдлагад санал зөвлөмж гарган хүргэе гэж байгаа юм.

ШХАБ-ын хүрээнд төр, засгийн тэргүүнүүд уулзаж олон баримт бичиг гаргаж байгаа. Гэхдээ ШХАБ-ын хамтын ажиллагаа яг бодитойгоор явж чадаж

байна уу, үгүй юү гэдгийг тогтоох, ер нь ШХАБ-ын талаарх судалгааг гүнзгийрүүлэх шаардлага байна. Өнөөдөр манай судлаачид тодорхой чиглэлүүдийг хувааж аваад судалж ажиллаж байна. Тэд тус тусын чиглэлээр хийж байгаа судалгааныхаа талаар товч танилцуулга хийнэ. Дараа нь асуух зүйл байвал асууя. Уригдаж ирсэн зочид санал бодлоо, байр сууриа илэрхийлж ярилцаж гэсэн бодолтойгоор бид энд цугларсан юм. /Н.Алтанцэцэг, Б.Дорж, С.Баясгалан нар товч танилцуулга хийв/

## Г.БАЗАРВААНЬ:

Танилцуулгатай холбоотой хоёр асуудал байна. 1. Монгол улсын гишүүнчлэлийн асуудал гэдэг нэр анхаарал татаж байна. 2. ШХАБ-ын хэгийн төлөвийг хэрхэн харж байгаа вэ. Таатай нөхцөл байдал болон бодит нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн харж судалж байна вэ гэдгийг асуумаар байна. Таатай нөхцөл байдал гэдэгт ШХАБ-д болж

байгаа үйл явц, процесс манайд ашигтай юм шиг боловч энэ байгууллага чинь эргээд манай гадаад бодлого, аюулгүй байдлын асуудалд яаж нөлөөлж болох вэ, ШХАБ-ыг цэвэр эдийн засгийн байгууллага гэж үзэж болох юм уу, улс төр, цэргийн байгууллага болохгүй байх баталгаа бий юу, эдгээр асуудал талаас нь харсан болов уу.

## Б.ДОРЖ:

Миний хувьд гишүүнчлэлийн асуудлыг сайтар судлах шаардлагатай гэж бодож байна. Бид энэ асуултанд хариулт өгөх зорилгоор цугларсан. Гэхдээ нэг хоёр дайралтаар хариу өгөхөд бэрхшээлтэй. ГХЯ-ны хувьд, түүнд бодлогын судалгааг хариуцаж байгаагийн хувьд та бүхний, судлаачдын бодол санааг тодруулъя гэж бодсон юм. Улс төрийн, улс төрчдийн хүсэл эрмэлзлийг дагаад явчихгүй байх хэрэгтэй. Улс төрчид улс төрийнхөө байдлаас болоод янз бүрийн түргэн шийдвэр гаргах гээд байдаг. Улс төрчид хэцүү л дээ, нэг хүн нэг уулзалт хийгээд, нэг сайхан юм ярихаар л энэ чинь ийм сайхан юм байна шд гээд л, энэ байгууллагад яагаад элсэхгүй байгаа юм, яагаад болохгүй байгаа юм гээд л байх. Төвийг сахих асуудал дээр ч гэсэн төстэй байдал үүсэж байсан гашуун сургамж бий. Тиймээс үүнийг судлаачдын түвшинд сайн судлая, консенсус бий болгоё гэж зорьж байгаа юм. Нөгөө талаар үнэхээр бодит ашиг олж, бодитой хамтын ажиллагаа байвал тэр зүйлээ идэвхжүүлэх хэрэгтэй байна.

ШХАБ-ын талаас бидэнд байсхийгээд л урилга ирж байдаг. Хууль зүйн сайдыг

нэг зүйлд оролцуулъя гээд л, эсвэл тийм байгууллагын шугамаар ийм хурал болох гэж байна гээд л.. тэгэхлээр эдгээрт бас оролцох хэрэгтэй байгаа юм л даа. Тухайн байгууллагатай энэ талаар ултай суурьтай харилцаж, ийм хамтын ажиллагаа явуулна гэсэн, ийм учраас энэ хуралд зайлшгүй оролцох ёстой юм, эсвэл ийм учраас энэ хуралд оролцоод хэрэггүй гэсэн хариу өгч байгаа монголын байгууллага байхгүй байна. Зүгээр л төсөв мөнгөний асуудлаас болоод би явж чадсангүй ч гэдэг юм уу, яг ажил хэрэгч байдлаар, эсвэл бодитой ашиг сонирхолын үүднээс хандаж байгаа зүйл байхгүй. Янз бүрийн уралдаан тэмцээн болоход зардлыг айлын тал дааж байвал бид нар оролцох жишээтэй. Зардлыг нь гаргахгүй бол хойшоо суугаад л, иймэрхүү алдаг оног, тохиолдлын чанартай, мөнгө төгрөгний байдлаас хамаарсан, ойр зуурын зүйлээс хамаарсан шинжтэй, ийм л зүйл яваад байна л даа. Тиймээс эдгээрийг аль болохоор идэвхтэй болгож бүх талын хамтын ажиллагааг эрчимтэй явуулдаг байвал зүгээр байна. Ер нь хамтран ажиллаж, харилцаж байж л бүх зүйлийг мэдэж авна шүү дээ.

## Ч.БААТАР:

Хамгийн гол нь ШХАБ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа нүдэнд харагдахгүй байна. Манайх бол Нэг бүс, нэг замын стратегид гурван улсын корридор гэдэг хүрээнд л оролцоод яваад байгаа юм биш үү? ШХАБ-

байгууллага гэдэг утгаар явж байгаа юм байхгүй. Хятадын хувьд голчлон хоёр болон гурван талаар юмаа хийгээд яваад байгаа, манайх тэр хүрээнд нь ороод яваад байгаа юм уу гэдэг асуудал бий.

## Х.БЭХБАТ:

Эдийн засгийн хамтын ажиллагаа гэнээс Хятад, Орос хоёроо ярихаа больё. ШХАБ-ын гишүүн бусад оронтой манай худалдаа, эдийн засгийн харилцаа гэж юу байна вэ, ойрын болоод цаашдын ирээдүйн төлөв юу байна вэ гэдгийг нэг үнэлж үзэх ёстой байгаа юм. Казахстантай юу байна, олигтой юм байхгүй, Киргизтэй юу байна, байхгүй, Узбекистантай юу байна, юу ч байхгүй. Шинжиантай юу байна, хилийн худалдаа гэж байна уу, үгүй юу, ганц нэг боомтын асуудал байгаа байх. Ийм байхад энэ чиглэлээр зүглээд, зүтгээд, улмаар цаашаа Энэтхэг, Пакистан гээд байх юм юу билээ. Энэтхэгтэй бид оюун санааны хөрш гэхээс нэг их илүү гарч чадаж байна уу? Тийшээ олигтой материаллаг юм гаргаж чадахгүй, харин нунтаг тамхи, шаазан заан маан л авчирдаг биз дээ. Зээлийн нэг асуудал бий. Ингээд үзэхлээр Төв болон

Өмнөд Азийнхантай түүх, соёл, улс төрийн харилцаанаас өөр юмгүй шахам байна. Ойрын ирээдүйд ч дорвитой юм гарч ирэхгүй биз. Төв Азийн орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшин, шаардлага, тэдний гадаад худалдааны бүтэц гээд харгалзах зүйл их бий. Тэгэхлээр ШХАБ эдийн засгийн хамтын ажиллагаанд их анхаарч байна, үүнийг дагаад бид их хөгжих нээ гэж бодож болмооргүй. Улс төр, аюулгүй байдлын хувьд ч бидэнд даацтай үндэслэл байхгүй байгаа учраас одоо хүртэл ажиглагчаар явж ирсэн байна. За нөгөө “3 аюул занал” л байгаа байх.

Гурван талын хамтын ажиллагаа, коридорын асуудлыг бид анх Улаанбаатарт ярьж байхаар гаргасан боловч ШХАБ-ын маржин / палиа дээр ярьдаг болсон. Бидний анхаарах ганц зүйл энэ л байна.

## Б. САНЖМЯТАВ:

Гол нь ШХАБ дотор Орос, Хятад хоёр байгаа, Хятад нь хэт давамгайлах гээд болдоггүй, тийм учраас Оросууд болгоомжилсон байр суурьнаас хандаж, олон талын хэмжээнд тодорхой юмаа гаргаж тохиролцож чадахгүй байна. Тэгэхлээр Хятадууд нэг бүс, нэг замын хүрээнд бүх зүйлээ хоёр талын хүрээнд хийгээд явж байна. Тиймээс таны хэлж байгаа ШХАБ-ын хүрээнд, далбаан дор явагдаж байгаа ямар нэг хамтын ажиллагааг энэ корридор гэж авч үзэж болно. Ерөөсөө нэг бүс, нэг замын хүрээнд 6 эдийн засгийн корридор байгуулна гэж байгаа, тэрний нэг нь манайх. Харин Монголынхоос бусад нь бүгд эхэлчихсэн явж

байгаа. Жишээ нь, Мьянмарын чиглэлээр корридор нь аль хэдийнэ байгуулагдчихсан, байгалийн хий, нефтийг түүгээр авч байна. Одоо Пакистан руу корридор гаргах гээд бариад эхэлчихсэн байна. Манай зүүн талаар байгалийн хий, нефть дамжуулах хоолойгоо барьчихсан. Казахстан бол байгалийн хийн хоолойгоо барьчихсан. Одоо Хятад нүүрс түлэхээ багасгаад, үүнтэй холбогдуулаад “Сила Сибири” гээд Эрхүүгийн орчмоос байгалийн хий дамжуулах хоолойны үйл ажиллагааг энэ 12 дугаар сараас эрс эрчимжүүлээд явчихлаа. Оросын газар нутаг дээр 1200 км барьчихсан гэж байна шүү дээ.

## Ч. БААТАР:

Тэр чинь Орос, Хятад хоёрын хоорондын хамтын ажиллагааны байгууламж шүү дээ. Тэрэнд ШХАБ-ын гишүүн бусад орнуудын оролцоо гэж юу байхав.

ШХАБ-д орчихоод Монгол учиргүй хөгжөөд явчихна гэсэн ойлголттой би санал нийлдэггүй. Орос 1912 онд Монголын талаарх бодлогоо тодорхойлохдоо гаргасан гол шийдвэр нь Монголыг хөгжүүлж болохгүй гэсэн чиглэл байсан. Харин Хятад бол ерөөсөө Монголыг хөгжүүлэх байтугай манай хэсэг гэсэн зүйлтэй хэдэн арван жил зууралдаж яваад ирсэн. Яагаад хөгжүүлж болохгүй вэ гэдгийг тэдний эрх ашгийн нүдээр харахаар зөв байгаа юм. Монгол хөгжөөд Сингапур шиг болоод ирэх юм бол энэ Буриад, Тува, Өвөр монголчууд шууд Монголд таагдана. Өөрөөр хэлбэл, хөгжил чинь татах хүчтэй байдаг. Тиймээс энэ хоёр гүрэн Монголыг хөгжүүлэхгүй гэсэн

суурь бодлоготой улсууд юм. Тэгэхлээр бид Монголыг хөгжүүлэхгүй гэсэн энэ хоёр улсын бодлогоос яаж гарах вэ гэхлээр гуравдагч хөрш улсуудтайгаа харилцаж, тэднээс эдний өгдөггүй үйлдвэрүүдийг Монголдоо оруулж ирж барихаас эхлээд, тэнд хүмүүсээ сургахаас эхлээд, тийм замаар л бид энэ хоёрын бодлогыг давах хэрэгтэй юм.

Гол нь бид бусдаар хийлгэдэг биш, харин өөрсдөө барьдаг болох ёстой юм. Монголыг хөгжилд хүргэх тийм үйлдвэрүүдийг Оросууд байгуулахгүй гэсэн бодлого барьж ирсэн. Оросууд хэзээ манайд гангийн болон төмөрлөгийн үйлдвэр барив, химийн үйлдвэр барив. Байсан нефтийн үйлдвэрийг нь хаагаа биз дээ. Улс орныг хөгжүүлдэг зүйлийг оросууд манайд оруулаагүй байхгүй юу.

## Х. БЭХБАТ:

ШХАБ-ын асуудлыг их гүрнүүд хоорондын өрсөлдөөний асуудал гэсэн өнцгөөс авч үзэж болно. Евразийн өргөн уудам нутгаас өрнөдийн орнуудыг шахаж гаргах, өөрсдийн эрх ашгийг түлхүү хамгаалах ийм зорилготой гэж АНУ болон бусад өрнөдийн орнууд үзэж байна. Тэгэхлээр аль байгууллагад орох вэ гэдэг асуудал бол үнэхээр сайн бодож байж шийдэх асуудал юм. Дэлхийн тавцан дээр улам ширүүсч байгаа геополитикийн өрсөлдөөнд аль талыг барих вэ гэдэг л асуудал юм.

Төв Азид хийгдэж байгаа хөрөнгө оруулалт нь ШХАБ-ын хүрээнд консенсууар шийдэж байгаа асуудал хараахан биш ээ. Одоогийн шаганд эдийн засаг, худалдаа, интеграцчилал гэж их ярьж байгаа нь бол улс төр, аюулгүй байдлын байгууллага гэдгээ бэхжүүлэхийн тулд авч явуулж байгаа арга хэмжээ. Худалдаа, эдийн засаг нь өөрөө энэ байгууллагыг авч явдаг тийм механизм бий болохдоо хүрээгүй байна. Эдийн засаг нь тус байгууллагын мотор болох яагаачгүй гэж судлаачид үздэг.

**К.ДЭМБЭРЭЛ:**

ШХАБ-д ажиглагчаар орсны дараа жил буюу 2005 онд Төв Азийн талаар хамтарсан бүтээл би гаргаж байлаа. ШХАБ-ын асуудлыг нэг төсөл яриад ч юм уу, таван хүн нэг төсөл гээд багцлаад боогоод явчдаг асуудал биш юм. Энэ бол ГХЯ ч юм уу, манай стратегийн судалгааны хүрээлэн ч юм уу нэг нэгж, эсвэл 2 хүн байна уу, 20 хүн байна уу нэг хоёр удаа ярьчих нь чухал биш, процессийг нь ажиглаж байх ёстой байгаа юм. Ажиглаж байна гэдэг бол хүнтэй байж ажиглана гэсэн үг. Байнга хараад процесс нь яаж явж байна, яах хандлагатай байна, энэ хоёр яаж уулзаж байна гэх зэргээр судалдаг судалгааны нэгж байх хэрэгтэй. Гэхдээ нэгж байна гээд санхүүжүүлснээр болохгүй, танай дээр, стратеги дээр төвлөрүүлэх хэрэгтэй. Сая л гэхэд бүрэн эрхт төлөөлөгч нь ирээд яриад явж байх жишээтэй. Үүнийг хариуцсан хүн нь ГХЯ-д ч байна уу, стратеги судлалын хүрээлэнд ч байна уу, үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ч байна уу, иймэрхүү зүйл болсон шүү гэх зэргээр үүн дээр судалгаа хийгээд зөвлөмж өгөх хэрэгтэй. Тэгээд үүнийг нь манай удирдлагууд ярьдаг байвал энэ зөв явж байна.

Дараагийн нэг зүйл бол, ШХАБ гэдэг чинь нэг сайхан торгон хөнжил байгаа юм. Орос, Хятад хоёр тэр хөнжлийг өөрлүүгээ татаж байгаа, ийм л асуудал байгаа. Одоо олон гишүүн элсэж байна л даа. Ингээд харж байхад эхлээд хуралдаа урьдаг байсан, сүүлдээ янз бүрийн зүйл хэлээд хуралдаа урьдаггүй болсон, энэ ямар учиртай вэ гэхлээр, бид улс төрийн зүйл хийгээгүй шдээ, бид судалгааны ажил л хийж байгаа гэдэг. Азербайжан, Армены төлөөлөгчид оччихоод мэндлэх ч үгүй суугаад байдаг. Уг нь бол эд нар судлаачид. Энэтхэг, Пакистаны төлөөлөгчид, судлаач нар нь оччихоод юм ярьдаггүй. Иймэрхүү байдалтай, ийм хамтын ажиллагааны байгууллага гэж байхгүй шдээ. Тэгэхлээр ШХАБ гэдэг чинь ийм л байгууллага байгаа шүү. Дараагийн нэг жишээ бол НАТО-гийн гишүүн Туркийг ШХАБ-д элсүүлнэ гэдэг, тийм зүйл байхгүй байхаа, тэр Турк гишүүн болох санаархалтай байна гэдэг бол юу л бол.

Бид нарын хувьд бол Орос, Хятад хоёр яах гэж байна вэ гэдгийг л харж байх ёстой. Энэ хоёрын хоорондын л харилцаа, угаасаа энэ

хоёр хоорондын харилцаа л манайд тусгалаа олно уу гэхээс биш өөр асуудлууд нээх их тусгал олохгүй. Энэ хоёр улс төр, эдийн засгийн хувьд ер нь ямархуу харилцаатай байна гэдгийг Монгол улс ажиглаж байх ёстой. Энэ л бидний ажиглалтандаа, анхааралдаа байлгах асуудал.

Өөр нэг асуудал нь сая Н.Алтанцэцэг багш ярьж байна, бид дундад Азийнхнийг оруулж яриад байгаа байхгүй юу, энд жишээ авч яриад л, тэд нар ингэж байна гэж яриад л байна. Эдгээр орнуудыг бид нар жишээ болгон аваад байх асуудал биш, яагаад гэвэл тэд нар онолын хувьд дөнгөж тусгаар тогтноод 20хон жил болж байна. Өөрийнхөө улсыг байгуулаад 20 жил болж байгаа улс чинь Орос гэдэг улсаас 100 хувь хамааралтай байж байгаад одоо хоёр дахь эх сурвалжаа олж хайж байгаа хүмүүс шүү дээ. Тиймээс тэд ШХАБ руу орж, тэр тусмаа Хятадтай наалдах нь тэдний амин эрх ашиг байгаа юм. Тэгэхлээр эд нарын хувьд Хятадын эрх ашиг орсон нь 50 хувь байгаа, нөгөө 50 хувь нь Орос байгаа юм. Эд нарын тусгаар тогтнол харьцангуй баталгаатай болж байна гэсэн санаа байгаа юм.

Дараагийн асуудал бол бид нар гуравдахь хөрш гэдэг асуудлыг тунхаглаад бараг 20 хэдэн жил болж байна. Энэбол Монгол Улсын амин чухал асуудал. Гуравдахь хөршийг сайн тайлбарлаагүйгээс болоод гадаадад биднийг буруу ойлгоод байна, нэг дэх нь хэн юм, хоёр дахь нь хэн юм, гурав дахь нь хэн юм, яах гэж байгаа юм гэсэн худлаа үнэн асуултууд байна. Гуравдахь хөршийг ер нь Орос, Хятад хоёртой дүйцэхүйц хэмжээнд гарч ирэхийг манай гуравдахь хөрш гээд байгаа юм. Эдийн засаг, улс төр, хүмүүнлэгийн бүх талаар харилцаанд нийлбэр дүнгээр бүгд тэнцүү байх, тоон утгаар бол яг 33.3, 33.3, 33.3 байхаар байгаа юм. ШХАБ-д гишүүн болвол гуравдахь хөрш гэдэг нэр томъёо автоматаар алга болно. Тиймээс энэ зүйл дээр бид зөв тайлбар хэлээд явах хэрэгтэй. Ажиглагчийн статус манайд хангалттай. Ер нь бол ШХАБ-аар дамжуулаад Орос, Хятад хоёртой Монголыг дамжин транзит тээврийн эсвэл эдийн засгийн үр ашигтай төсөл хэрэгжүүлсэн бол гурван тал хамтран хэлэлцэх асуудалтай болох байлаа.

## Г.БАЗАРВААНЬ:

ШХАБ-ын талаар манай хүрээлэнд суурь судалгаа ерөнхийдөө хийж байсан, хийдэг. Манайх жил болгон Ерөнхийлөгчийг ШХАБ-ын уулзалтанд явах болгонд зөвлөгөө өгдөг. Бидний баримталж байгаа ганц зарчим бол энэ байгууллагын эдийн засгийн юм уу эсвэл улс төрийн бодлого нь тодорхойгүй байгаа юм. Тэр утгаараа бид одоогоор ажиглагч байх хэрэгтэй гэдэг. Монгол улсын гадаад бодлогод бүс нутгийн аливаа интеграцид нэгдэж орох асуудал байгаа, гэвч манайхыг тойроод гарч байгаа энэ олон улсын байгууллагуудыг түлхэхэд хэцүү, түшихэд хэцүү. Ийм байгууллагын нэг бол ШХАБ. Тиймээс бид ажиглаж байх хэрэгтэй. ШХАБ өөрөө маш их ялгавартай байгууллага. Төгс төгөлдөр ОУБ гэж байхгүй. НҮБ ч гэсэн төгс биш. ШХАБ гишүүнчлэлийн дүрмээ сая 2015 онд л баталсан. Тэрнээс өмнө 2008 онд Афганистан, мөн онд Иран гишүүнээр элсэх өргөдлөө өгсөн, одоо болтол шийдвэрлээгүй байгаа. Үүнээс хойш түрүүний ярьсан Израиль, Сири, Вьетнам, Бангладеш, Мальдив, Египт гээд улсууд ажиглагчийн статустай байх өргөдлөө өгсөн, одоо болтол шийдвэрлээгүй байгаа, тэгсэн мөртлөө манайхыг болохоор ямар нэгэн шалгуургүйгээр гишүүн болгох бүрэн боломжтой гэдгийг илэрхийлж байгаа нь үндсэндээ манай хоёр хөрш Монголд ашиг сонирхолоо тулгах бас нэг байгууллагатай болохыг л хэлээд байгаа юм. Энэ байгууллагыг бид юу гэж харж байгаа вэ гэхлээр цаашдаа цэвэр улс төрийн эвсэл болчих вий дээ, яагаад гэвэл сүүлийн үед ШХАБ-ын хийж байгаа хээрийн сургуулиуд 10000 цэргийн бие бүрэлдэхүүнийг оролцуулж байна. Үүнийг харвал эдгээр улсууд цэвэр байлдааны ажиллагаанд бэлдэж байна гэж үзэхээр байна. Дээрээс нь манайхтай ч их ойрхон хийсэн шүү дээ. Энэ бүх байдлыг харвал танайх ШХАБ-д ороочээ гэсэн дохио манайд өгч байна. Сая манайд ирсэн Хахим ШХАБ-д биднийг элсэхэд ямар нэгэн саад байхгүй гэж хэлж байгаа.

ШХАБ-ын эдийн засгийн хамтын ажиллагаанаас гарсан үр дүн байхгүй.

## Т.СҮХБААТАР:

Би өөрийн үзэл бодлоо хэлбэ, манай хүрээлэнгийн байр суурь биш шүү. Судлаач хүний хувьд. Түрүүнээс хойш сонсоод байхад эдийн засаг л гэж яриад байх юм. Яг ШХАБ-д элсээд эдийн засаг нь сэргэчихсэн ямар улс орон байна вэ?. Төв Азид Киргиз зэрэг эдийн засаг нь сэргээгүй улсууд байж л байна. Дээрээс нь эдийн засгийн ач холбогдлыг их

ШХАБ-ын банк л гэнэ, хөгжлийн банк л гэнэ, гэхдээ ер нь Хятад мөнгө хөрөнгөө хаашаа зарцуулахаа өөрөө шийдээд байгаа юм. Тэрнээс биш эдийн засгаар улс орнуудыг дэмжсэн зүйл байхгүй. Хятад нэг бүс, нэг замыг гаргаж ирснээр үндсэндээ ШХАБ-ын асуудал хоёрт тавигдаж байна. Энэ төслөөр маш олон оронд хөрөнгө оруулалт хийж байгаа. Тэгэхлээр Хятад өөр улс орнуудад оруулсан хөрөнгө оруулалтаа шаардлагатай тохиолдолд цэргийн хүчээр хамгаалах гэж байгаа. Магадгүй энэ байгууллагыг тийм байдлаар ашиглах боломж олгох вий. Яагаад гэвэл энэ нь Хятадын тодотголтой цорын ганц олон улсын байгууллага юм. Манай тал гишүүнчлэл гэдэг ойлголт байхгүй шүү гэдгийг хэлж байгаа. Харин янз бүрээр хэлж болж байгаа юм л даа. Эхлээд бид ажиглагчийн байр суурьтай оролцоно, дараа нь идэвхтэй ажиглагчийн байр суурьтай оролцоно гэж байсан, тэрнээс биш гишүүн болох асуудал одоогоор байхгүй ээ гэж ойлгож байгаа. Мөн Энэтхэг ШХАБ-ын гишүүн болсноор Орос, Хятад, Энэтхэгийн зөрчлийн байгууллага болно. Эдгээр гурван улс хоорондоо ашиг сонирхолын асар их зөрчилтэй. Дээрээс нь энэ байгууллагын гол онцлог нь зөвшилцлийн байгууллага. Нэг нь санал өгөхгүй байхад л асуудал шийдвэрлэхэд бас хэцүү. Энэтхэг, Пакистан хоёр орсноор саналын асуудал ЕАБХАБ-ийн 57 улстай адилхан болно. Гишүүн улсууд нь цөөхөн хэдий ч асуудлыг маш удаан шийдвэрлэдэг байгууллага болж харагдаад байна.

Бид нар ШХАБ судлалын төв гэдгийг ГХЯ-д санал болгосон байж байгаа. Үүний гол зорилго нь ШХАБ-ын гишүүн орнуудын судлаачдын форум гэж болдог л доо, энд бүх улсуудаас ШХАБ-аа хариуцсан судалгааных нь хүмүүс ирдэг. Дээд хэмжээний уулзалтын өмнө болдог, тэдгээр нь ШХАБ-ын хүрээнд юу яригдах вэ гэдгийг урьдчиллаад ярилцдаг, ийм л тогтолцоотой байдаг. Манайх Евразийн эдийн засгийн холбоо болон ШХАБ судлалын төв гэдгийг хүрээлэндээ байгуулахыг оролдож байгаа, за ийм л бодолтой байна.

муутайг нь далимдуулан тулгаад байгаа юм болов уу гэж бодох юм. ШХАБ-д элсэх талаар маргаан гардаг л даа, жишээ нь ШХАБ-д элсчихвэл АНУ гомдоно ч гэдэг юм уу, элсэхгүй бол Орос, Хятад гомдоно ч гэдэг юм уу, иймэрхүү яриа их байгаа. Энэ талаарх олон нийтийн мэдээлэл маш хангалтгүй байна. Яагаад элсэх, эсвэл элсэхгүй гээд байгаагаа маш сайн тайлбарлах хэрэгтэй юм шиг. Элсээд орчихоор өмнө нь хэлсэн шиг эдийн засгийн ашиг сонирхол ч юм уу, ямар нэгэн ашиг сонирхол байна уу, ямар ашиг хонжоо байна. Элсэхэд голдуу эдийн засаг талаас нь ярьж л байна л даа. Тэгэхлээр ШХАБ-д орохоор эдийн засаг өнөөдрийн

байдлаас дээшээ сэргэчих юм уу, эсвэл өнөөгийн эдийн засгийн хямралд ШХАБ буруутай юм уу, ШХАБ-д л элсэхгүй байгаа учраас манай эдийн засаг уначихаад байгаа юм уу. Тэгвэл ШХАБ-д л элсчихвэл манай эдийн засаг сэргээд ирэх юм уу. ШХАБ-д үнэхээр элсэнэ гэвэл үндэслэлээ хангалттай гаргаж өгөх хэрэгтэй. Ямар үндэслэлээр яг яах гэж ШХАБ-д элсэх гээд байгааг. Миний хувьд хэдийгээр ШХАБ-д элсэн орж болох ч яг цаг нь бол болоогүй гэж боддог. ШХАБ үнэхээр тулгамдсан асуудал мөн үү, тэгэхлээр энэ асуудал бол хоёр хөршөөс үе үе ирдэг дарамт шахалт юм болов уу гэж ойлгож байна.

## Х.БОЛДБАТ:

ШХАБ-д элсэхгүй явсаар байгаа нь манай эдийн засгийн хөгжлийн хувьд болохгүй байна гэсэн яриа байдаг. Энэ нь нэг байдлыг нөгөө байдалтай хамаагүй аваачиж хүчээр холих гээд байна уу даа гэсэн ойлголт төрүүлээд байна. Жишээ нь, зөвхөн ШХАБ-д элсэн орсоноор л Монголоор дамжсан зам тавигдахгүй шдээ. Яагаад гэхлээр эдийн засгийн тооцоон дээр л суурилагдаж байгаа учраас. Үнэндээ Монголын зам бол нэг улсын зэлүүд нутгийг нөгөө улсын зэлүүд нутагтай холбодог л зам шүү дээ. Тэгэхлээр аль болох эдийн засгийн үр ашгийг тооцоод хийх зүйлийг бид нар холоос харчихаад, бид нар вагонд нь суугаагүй учраас хоцорчихлоо гэж өөрсдийн толгой дээр үнс асгадаг нь нэг талаар буруу юм шиг байгаа юм л даа. Үүнийг нэлээн холоос олж хармаар санагдаад байна. Манай эдийн засгийн байдал, дэд бүтцийн

хөгжлийн түвшин нь бүс нутгийн болон ШХАБ, өөр юу ч байж болно бүс нутгийн хамтын ажиллагааны аливаа механизмд татагдан оролцоход нэг ёсны түгжээс болж байна. Тэр утгаараа Монгол ШХАБ-д орчихлоор л Монголын төмөр замыг хоёр салаа болгоод, цахилгаанжуулаад, бөөн зардал гаргаад явчихна гэж бодохгүй байна. Дээрээс нь улс төрийн маш тогтворгүй айл, энэ мэт зовлон их бий. Мэдээж хэрэг том төслүүд нь эдийн засгийн үр ашигтай байх гэдэг үүднээс хөдөлж байна биз. Гэхдээ нэг болохгүй байгаа асуудлыг нөгөөтэй нь хольж хутгаад байхаар бидэнд тодорхой байр суури илэрхийлэх боломж маш хязгаарлагдмал болно. Тиймээс юмыг чиглэл чиглэлээр нь, тодорхой тодорхойгоор нь гаргаж ирсэн нь дээр байх гэсэн саналтай байна.

## Н.СОЁЛГЭРЭЛ:

Би ШХАБ-ын судлаачдын 3-4 хэлэлцүүлэгт явж оролцож байсан, үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тухайн үед яг Монгол улс ямар байр суурь баримталж, манай улс ямар статустай байх ёстой юм бэ гэдэг дээр бодлогын зөвлөмж өгч байлаа. Одоо ерөнхийдөө тэр зөвлөмжийн дагуу манайх явж байгаа байх. Хэд хэдэн сценари дэвшүүлэн судлаад олон талтай хувилбар гаргаж өгдөг. Бид нарт ийм ийм боломж байна, тухайн үед бид нар ШХАБ-ыг ядаж 3 туйлтай болгохын тулд гуравдагч хөрш болох Энэтхэгийг орохыг харзнаа гэж байсан. Ямарч байсан Энэтхэг энэ жил гишүүн болчихлоо. Энэ нэлээд удаан хугацааны үйл явц байсныг бид мэдэж байгаа. ШХАБ-д Орос, Хятад хоёр зайлшгүй яригдана. Энэ бол Орос, Хятад хоёрын нөлөөний том интеграци.

Бид ШХАБ-ыг ярихдаа гуравдагч хөршийн бодлогыг нялж, нэгийг нөгөөтэй нь дэнслэх нь маш буруу гэж бодож байна. Гуравдагч хөршийн бодлого нь манай хувьд маш өндөр ач холбогдолтой бодлого байсан, одоо ч байгаа. Энэ бодлого 27 жил үүргээ гүйцэтгэж байгаа, цаашдаа ч Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд нэлээд үүрэг, оролцоотой байх гадаад бодлогын чиглэл юм. ШХАБ бол Монгол улсын хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах бодлогын хүрээнд бол чухал юм. Хоёрт, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол улсын үндэсний аюулгүй байдал хангагдана гэдэг нь гадаад, дотоод аюулгүй байдал тогтвортой хангагдсан байхыг хэлнэ” гэсэн байдаг. Гадаад аюулгүй байдлын хувьд бид хоёр бүс нутгаа ойлгож байгаа юм, хөршүүдээ ойлгохоос гадна. Энэ бол зайлшгүй

Төв Азийн чиглэлийн интеграцийн асуудал юм. Энэ үүднээс харвал анхаарах ёстой юм байгаа. Нөгөөтэйгүүр, ШХАБ-д бид 2004 онд ажиглагч болж ирсэн гэдгээс илүү бид хамгийн анхны ажиглагч болсон гэдгийг арай илүү анхаарах ёстой юм. Узбекистан улсын гишүүнчилэл их сонирхолтой. Энэ улс нөхцөлтэй элссэн гэж үздэг. Улс төр, аюулгүй байдлын ажиллагаанд түлхүү оролцохгүй гэж элссэн.

Хэрвээ бид цаашдаа ШХАБ-д элсэнэ гэдэг байр суурь баримталвал маш олон чиглэлээр судалгаа хийх ёстой. Ерөнхийдөө Монгол улсад ШХАБ-ын талаарх системтэй судалгаа маш дутмаг байгаа. Ганцхан энэ асуудал дээр л гэхэд судалгаа шаардаж байх жишээтэй. Түүрүүн эдийн засгийн болон улс төрийн бүтэц нь тодорхой болсон гэж хэлж байсан. Тодорхой болсон гэвэл тун хэцүү байна. Орос хөгжлийн банкны санаачилга гаргасан. Хятад үүнийг нь зөвшөөрсөн, гэхдээ Бээжинд төвтэй байгуульга гэсэн. Оросын эрх ашигт энэ нь нийцээгүй. Тийм болохоор хөгжлийн банкны асуудал гацсаар байгаад өдийг хүрсэн. Тэгэхлээр Орос нь цааргалж байна гэдэг бол Орос өөрөө аюулгүй байдал, хамтын ажиллагааны чиглэлийг магадгүй түлхүү хөтлөх сонирхол байгаа байх. Хэрвээ эдийн засгийн чиглэл рүү нь түлхүү хөтлөөд Хятадын доор явахаар болох юм бол Хятадын нөлөөнд хэт дарагдчих гээд байгаа. Өнөөдөр хэн нь эдийн засгийн хувьд хүчтэй, чадалтай байгаа билээ. Хоёр их гүрний ийм бодлого явагдаад байх шиг байна. Бид нар үүнийг харж байх ёстой. Тэгэхлээр тинк танкийн асуудал маш чухал байгааг өмнө хэлсэн байна. Судлаачдын уулзалтанд оролцоод явж байхад ШХАБ-ын гишүүн улсууд бүгд нэг том том төрийн мэдлийн тинк танкийн дэргэд ШХАБ судлалын төвийг авч явдаг. Тэдгээр нь маш өргөн хэмжээний судалгаагаартай. Хятадад бол СИС гээд тинк танк байдаг, тэрний дэргэд ШХАБ-ын судалгааны төв байна, Орост МГИМО-ийн дэргэд байна, Казахстанд Назарбаевын дэргэдэх Улс төр эдийн засгийн судалгааны хүрээлэн гэж байдаг, тэрний дэргэд ШХАБ-ын судалгааг төвлөрүүлсэн байдаг. Тэрэн шиг манайхан бас түшиглээд өөрсдийн гэсэн төвийг бий болговол зүгээр. ШХАБ-ын дараагийн жилүүдэд ач холбогдол өгч, дунд хугацааны хөтөлбөртөө зорьж байгаа нэг асуудал бол шинжлэх ухаан, боловсрол, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа юм. Тэгэхлээр бид нар ямар ч байсан судалгааны түвшинг шинэ шатанд гаргая гээд, идэвхтэй ажиглагч байр суурин дээр байх хүсэлтээ илэрхийлээд, өөрсдөө санаачилга гаргаад явахад энэ байгууллагад идэвхтэй тоглогч байж болох юм.

Энд яригдсан асуудлын дотор Сири улс, Исламын улс бүлэглэлтэй холбоотой асуудал орно. Үнэхээр ШХАБ-д өнөөдөр ямар нөхцөлд элсэх вэ гэдэг асуудал байна. Эхнийх нь

Энэтхэг орвол гэж байсан, дараагийнх нь бүрэн институцилэгдсэн байх нөхцөл тавьж байгаа. Гэтэл ШХАБ нь бүрэн институцилэгдсэн байж чадаж байна уу гэвэл учир дутагдалтай. Түүрүүн Болд гуайн хэлсэн шиг ганцхан РАТС байна. Ташкентэд төвтэй бүс нутгийн терроризмын эсрэг бүтэц гэж байна. Өрнөдийн шинжээчид үүнийг маш сайн ажиллаж байгаа гэж дүгнэдэг. Цаашдаа Афганистаны асуудал байна, Афганистан бидэнтэй адилхан ажиглагч статустай болсон. Хоёрт Сири улсаас дүрвэн буцаж байгаа террористууд хаана дараагийн түшиц газраа хайх вэ гэдэг дээр Москва санаа зовж байна. Вашингтон бас адилхан санаа зовж байна. ТУХН-ээс 8000-10000 орчим иргэд очиж Исламын улс бүлгийн эгнээнд орж Сири, Иракт дайтсан гэсэн тооцоо байдаг. Тэднээс буцаж 5000-6000 нь ирнэ гэж үзэж байгаа. Эдгээр дайчид хаагуур дамжих вэ гэхлээр нэгд Туркээр дамжин ирж байна. Монгол улсын аюулгүй байдалтай шууд холбоотой өнцөг нь манайх Турктэй визгүй, бас шууд нислэгтэй. Үүн дээр бид анхаарал тавин ажиглаж байх ёстой. Хоёрт эдгээр дайчид Афганистанд, эсвэл Таджикистан төвлөрнө гэж таамаглаж байсан, одоо түшиц газар нь болж байна. Эхний халдлагаа Афганистанд хийсэн. Тэд талибантай нөлөө, нутаг дэвсгэрээ булаалцах алхам хийж байна.

Би энэ зун болсон дээд хэмжээний уулзалтанд ШХАБ юунд анхаарч вэ гээд бүх баримт бичгүүд дээр нь судалгаа хийсэн. Тэгэхэд дотоод хамтын ажиллагааны чиглэлд 11 баримт бичиг батлаад, эд нарынх нь 70-80 хувь нь хэт даврах үзэл, терроризмын эсрэг, аялал жуулчлал, хүмүүнлэгийн болон аюулгүй байдлын чиглэл рүү байна. Гадаад аюулгүй байдлын чиглэлээр юунд анхаарч байна вэ гэхэд энд нэг онцлог асуудал ажиглагдсан. Нэгд, ШХАБ-ын ажиглагч улс Афганистаны асуудлын гол зохицуулагч нь НҮБ байхыг онцолсон байна. Тэгэхлээр энд НАТО-г үл хайхарч байна л даа. Хоёрт, Сирийн асуудлыг улс төрийн арга замаар шийдвэрлэхийг онцолж, Казахстаны зуучлал болох Астанагийн процессын үүрэг ролийг чухалчлав. Энд нөгөө Женевийн хэлэлцээ байхгүй болсон байх жишээтэй. Гуравт, ажиглагч улс Ираны цөмийн хөтөлбөр тойрсон асуудлыг Иран болон Европын Холбоог багтаасан 6-ийн бүлгийн хүрээнд шийдвэрлэх гэснээр Ираныг оруулж ирж байна. Дөрөвт, Украйны хямралыг Минскийн зөвшилцлийн замаар шийдвэрлэх бүрэн боломжтой гэж байна. Дандаа өөрийн нөлөөний бүс рүү татсан байдлаар олон улсын асуудлыг дүгнэж үзэж байна. Эдийн засгийн асуудлын хувьд хэд хэдэн чиглэл байгаа нь яг бодитой техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдчихсэн ч юм уу гэхээр тийм эдийн засгийн төсөл нэг ч харагдахгүй байна

# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

## 2018 ОНЫ 2-Р САР

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 2 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны эцсийнхээс 2.2 хувь, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.0 хувь (төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 16.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 12.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.0 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 11.5 хувь (тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 23.5 хувь), орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 19.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 2 дугаар сард өмнөх сараас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлэг дүнгээрээ 2.9 хувь, согтууруулах ундаа, тамхины үнэ бүлгийн дүнгээрээ 0.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

## НОМЫН ЕРТӨНЦӨӨР

Арван хоёр жил Элчин сайд.



Ингэж нэрлэсэн ээлжит номоо Бадамдоржийн Батхишиг маань өнгөрсөн оны эцсээр нийтийн хүртээл болгосон юм. Ажил амьдралын арвин баян түүхтэй, эрдэм номын шаггүй өв бүтээлтэй энэ эрхэм Монгол Улсын дипломат албанд зүтгэсэн 12 жилийн дурсамжаа эл номондоо хүүрнэжээ.

Эдийн засагч, багш, доктор Б.Батхишиг эрдэм, боловсруулахуйн мөр хөөж, хэрхэн улс төрд зүтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд шадарлаж явсныг манай олон нийт мэднэ. Энэ удаа тусгаар улсаа төлөөлж, үндэсний эрх ашгаа олон улсын хэмжээнд хамгаалан урагшлуулахын учирьг эзэмшсэн он жилүүдээ “тайлагнасан” нь түүнийг төрийн бат түшээ гэдгийг дахин нотлохын сацуу өөрийнх нь тэр шаргуу, ажилч хичээнгүй, гярхай, нөхөрсөг гээд бүхий л сайн чанарыг нь лавшруулан харуулжээ. Энэ 12 жил манай гадаад харилцаа, дипломат албаны түүхийн судалгаанд үнэтэй хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй ээ.

Х.Бэхбат

📍 Монгол улс, Улаанбаатар хот, СБД,  
МУИС-ОУХНУС V байр 308 тоот

✉ [thinktanks99@gmail.com](mailto:thinktanks99@gmail.com)

☎ 976 99070579

☎ 976-11354610

